

Олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд Улаанбаатар театрын хөгжимчид гэр гэрээсээ мэндчилж, “Бусаддаа гэрэл түгээ”, “Бид хамтдаа уриалгыг дэвшүүлж С1 телевиз, өлзий телевиз, youube-ээр дэлхийн сонгодог аянуудыг ардыз хөгжмөөр тоглож ард тумэнд хүргэсэн.

2. Yanni “World dance”
3. Coldplay хамтлаг “Viva la vida”
3. Taro Hakese “JonetsuTaireku” дуунуудаар онлайн контент хийж сошиал сүлжээнд нийтлүүлэн үзэгчдэд хүргэлээ.

#### **1.4. Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт**

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил эхний хагас жилд байхгүй болно.

#### **1.5. Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл**

Монголын ард түмэн олон зуун жилийн тэртээгээс үндэснийхээ түүх соёлын хосгүй нандин өв, дурсгалуудын дотроос онцгойлон эрхэмлэж, бүтээн турвиж өвлүүлэн уламжлуулсаар эдүгээ хурсэн манай соёлын үнэт өв, үндэсний бахархал болсон монгол уртын дуу, морин хуур хэмээх энэхүү гайхамшигт бүтээлийг ХХ зуунд тайз дэлгэцийн урлагтай хослуулан хөгжүүлснээр, олон зуун авьяастан, мэргэжлийн уран бүтээлчид төрөн гарч үндэсний соёл урлагaa олон улсын түвшинд сурталчлан таниулахад чухал шинэчлэл болж уртын дуу, морин хуураа хойч үедээ уламжлуулан судлан сурталчлахад үнэтэй хувь нэмэр оруулж байна.

“Бий Биелгээ” нь олон ястны түүх, уламжлал, заншил, дуу хөгжим, үлгэр домог, туульс, хувцас өмсгэл, тоглоом наадам зэргийг өргөн утгаар нь өөртөө цогцлоон багтааж уламжлагддаг ба үндэстэн, ястнуудын амьдрал, өвермөц ахуй байдал, ёс заншил, уламжлал, сэтгэлгээний онцлогийг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх бүжгийн урлаг юм. Биелгээг гэрт, тойрон суусан хүмүүсийн дунд, зайдагатай газар бүжиглэдэг байснаас цээж гарын хөдөлгөөн нарийн хөгжсөн бөгөөд монгол хүний ажил үйлс, зан үйл, хэв шинж, амьдралын агуулгыг биелзээч хүний сэтгэлийн хөдлөл, уран намбаар биелж харуулдаг гайхалтай урлаг билээ. Энэхүү өв соёлыг ард түмэнд түгээн дэлгэрүүлж сурталчлах зориолгоор бүжиг дэглээч, бүжгийн багш Д.Баярт болон театрны бүжигчид “Монгол ТВ”-ийн өглөө хөтөлбөрт орж ард түмэнд цэнхэр дэлгэцээрээ дамжуулан бие биелгээ заалаа.

#### **1.6. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт;**

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээр **1.1.1**, гэсэн 1 ажил төлөвлөгдсөн бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар хэрэгжилт 70%-ийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр **2.6.3.1**, **2.6.4.1**, **2.6.6.4**, дахь заалт буюу 3 ажил тусгагдсанаас 2022 оны хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.

**1.1.1** Урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх замаар, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлын эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлсэн байна.

Монголын уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг таниулан сурталчлах, үндэсний хөгжмийг орчин үеийн цахилгаан хөгжимтэй хослуулсан шинэлэг хэлбэрийн онлайн тоглолт зохион байгуулах.

**Хэрэгжилт:** Театрын урын санг баяжуулж, үндэсний урлагийг иргэд, олон нийт, гадаад дотоодын зочид-төлөөлөгч-жуулчдад таниулан сурталчлах ажлыг эрчимжүүлэхээр, эхний хагас жилийн байдлаар урын сандаа 30 гаруй шинэ уран бүтээлийг оруулж, Нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн болон гадаад дотоодын жуулчин, төлөөлөгч нийт 25000 гаруй иргэдэд хүрч үйлчилсэн байна. Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Нийслэлийн Соёл Урлагийн газартай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн ажлын хүрээнд ХОРЕКА зочид буудал, зоогийн газрын EXPO, Олон Улсын Номын баяр, Гэгээн Муз" олон улсын театрын наадам, "Дээлтэй Монгол", "Даншиг Наадам-Хүрээ цам", "Улаанбаатар" аялал жуулчлалын үзэсгэлэн, "Талын салхи" олон улсын мото наадам зэрэг арга хэмжээнүүдэд оролцож, ард иргэдэд ардын болон орчин цагийн урлагийг таниулан сурталчлах ажлуудад уран бүтээлээ өргөж ажиллалаа. Жуулчны улирлыг угтаж Улаанбаатар театрын бренд болсон "Colors of Mongolia-2022" ардын урлагийн тоглолтын шинэчилсэн найруулгыг контент болгон бэлтгэж, Жуулчин ХХК, Нью Жуулчин Тур, Үж Хан тур зэрэг тур оператор компаниутай гэрээ хийн хамтран ажиллаж байна.

#### 2.6.3.1 "Хотын соёл" цуврал контент бий болгож, цахим аян хэрэгжүүлнэ.

**Хэрэгжилт:** НСУГ, НЗДТГ-ын санаачилгаар "Хот соёлтой болгоё. Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх нь хүн бүр өөрөөсөө эхэлж, үр хуухдуудээ зөв үлгэр дуурайдал үзүүлэхээс гадна бусдын төлөө сэтгэж, нийгэмдээ юу хийж чадах вэ Мөн олон нийтийн дунд биеэ зөв авч явж, бусдад саад учруулах үйлдэл хийхгүй байх, ил задгай шүлс, хогоо хаяхгүй, бусдадаа үлгэрлэж, байгаль дэлхийгээ хүндэлж харьцах нь эргээд бидний ирээдүйн нийгэм түүний хэрээр сайхан байх үндэс бүрдэнэ гэдийг нийт иргэдэд түгээн дэлгэрүүлэх үүднээс тус театрын сошиал сүлжээн дэх фейсбуук хаягаар дамжуулан олны танил уран бүтээлчдийн оролцоотой бүтээгдсэн видео шторкуудыг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан. "Замын хөдөлгөөний соёл, "Хотын түүхийг хоёр минутад-Их хүрээний нүүдлийн шалтгаанууд". "Хайртай Хот" зэрэг богино хэмжээний шторкийг театрын сошиал хуудсаар цацсан байна.

#### 2.6.4.1 Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжинэ.

**Хэрэгжилт:** Монголын үндэсний хөгжмийн хөг эгшиг дахин давтагдашгүй өнгө төрх хийцтэйгээр дэлхий дахинд гайхагдаж байгаа өнөө үед соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, сурталчлан таниулах нь Монголчууд бидний бахархал юм. Дэлхийн сонгодог болон орчин цагийн бүтээлүүдийг Улаанбаатар театрын Хөгжмийн зохиолч О.Чинбатын шинэчилсэн найруулгаар үндэсний хөгжмийн зэмсгүүдээр гадаад, дотоодын үзэгч, сонсогчдод мэргэжлийн өндөр түвшинд уран бүтээлүүдээ туурвин хүргэх үүднээс 2022 оны 3-р улиралд "LEGEND OF MUSIC" хөгжмийн тайлбарт тоглолтыг тусгасан. Уг тоглолт нь Монголын үндэсний хөгжмийн зэмсгийн гарал үүсэл, хөг хийц, хөгжил дэвшил, техник ур чадварыг бүрэнгүйцэт илэрхийлэх онцлогтой бүтээл юм. Тус контент нь морин хуур, шанс, лимбэ, их хуур, еочин, эвэр бүрээ. ятга. цан бөмбөр гэсэн 8 хөгжмийн зэмсгийн тухай танилцуулга бүхий ковер бүтээлүүдийг үндэсний хөгжмийн зэмсгээр тоглох, цахим болон тайэнэ

хэлбэрийн бүтээл болгон үзэгчдэдээ өргөн барих юм. Энэ ажлын эхний хэсэг болох хөгжмийн зохиол нь бичигдэж, аудио бичлэгийг Дуу бичлэгийн ЭВ продакшны студид бичигдэж, видео бичлэгийн ажил эхэлэхэд бэлэн болоод байна. Хөтөлбөрийн бүтэц 11 бүтээлтэй. Мөн театрын урын санд багтсан гилмэл бүтээлүүд болох Анхны унсэлт мюзизл, Ариун хаврын тахилга Этно балет, Five Tones хөгжмийн тоглолт зэргийг сэргээн шинэ бүрэлдэхүүнээр тоглож, үзэгчдийн хүртээл болгосон. Сэргээн тавьсан 4 бүтээлийг тайлант хугацаанд 8 удаа тоглож, 3500 гаруй үзэгчдийг хамруулсан байна.

**2.6.4.3 Иргэд жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагааг зохион байгуулна. /ковидоос шалтгаалж/**

**Хэрэгжилт:** 2022 оны 07 дүгээр сарын 01-ний өдрөөс хүртэл 2-сарын хугацаанд өдөр бүр 18 цагаас гадаадын жуулчдад зориулсан "COLOR'S OF MONGOLIA" тоглолтыг өөрийн тайзнаа "Анхаа трэйвэл" ХХК, "Үж Хан" ХХК, "Мини Тувер" ХХК, "Эм Би Зэт Ай" ХХК -тай хамтран зохион байгуулж ажиллах гэж байна.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийг биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болон алхалт гүйлтээр хичээллэхэд уриалах, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах зорилгоор Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулж буй "Илүүдэл жингүй, Эртэч Монгол" аян улс орон даяар болж байгаатай холбогдуулан Улаанбаатар театрын албан хаагчид нэгдэж дасгал хөдөлгөөнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тогтмол хийж эрүүл мэндээ хамгаалах, илүүдэл жингээ хасах аянд нэгдсэн.

Тус "Илүүдэл жингүй-Эртэч монгол" хөтөлбөрийн хүрээнд театрын Биеийн тамирын хамтлагийн ахлагч Б.Өнөрцэцэгээр ахлуулсан баг Лхагва гараг бүрийн өглөө дасгал хөдөлгөөнд хамт олноо уриалж, ритмт дасгалууд болон иогын хичээлийг тогтмол орж хэвшсэн.



## ХОЁРДУГААР БҮЛЭГ: "ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"

### **2.1 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны хагас жилийн байдлаар**

**a/ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 дугаар тушаалын 7-р хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/206 дугаар тогтоол, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын хүрээнд Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тайлан мэдээг цаг тухай бүр нь хэрэгжүүлж ажиллаж байна.**

#### **б/ Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт**

##### **1. Нийслэлийн Засаг даргын 2006 оны 04 дугаар сарын 11-ны өдрийн А/165 дугаар захирамжийн хэрэгжилт**

**Заалт:** Спортын хамтлаг байгуулах тухай

**Хэрэгжилт:** Нийслэлийн Биеийн тамир спортын газраас ирүүлэсэн Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэдийн дунд биеийн тамир спорт чийрэгжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, спортын хамтлаг байгуулах Захирамжийн хүрээнд Улаанбаатар театр нь 2022 оны 02 дугаар сарын 08-ний өдөр 9 хүний бүрэлдэхүүнтэй спортын хамтлагыг байгуулж төлөвлөгөө гарган байгууллагын даргаар батлуулж ажилласан.

##### **2. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн А/480 дугаар захирамжийн хэрэгжилт**

**Заалт:** 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарлах тухай

**Хэрэгжилт:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагаа хөтөлбөр Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, хүнд суртлыг бууруулах, төрийн албан хаагчдын ажлын бүтээмж, иргэдэд үзүүлэх төрийн "үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар театр нь 5 ажил хийхээр төлөвлөгөөг байгуулагын даргаар батлуулж тайланг заасан хугацаанд нь НЗДТГ-т хүргүүлж ажилласан.

##### **3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн А/480 дугаар захирамжийн хэрэгжилт**

**Заалт:** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

**Хэрэгжилт:** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2022 оны 06 дугаар 01-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж Улаанбаатар театрын хөгжмийн зохиолч О.Чинбат өөрийн урын сангын тоглотын хэсгээс хүүхэд багачуулдаа хүргэсэн.

##### **4. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн А/578 дугаар захирамжийн хэрэгжилт**

**Заалт:** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

**Хэрэгжилт:** Хүний хувийн мэдээлэл тухай хуулийн 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг усгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар театр нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг судалж танилцан, Биеийн давхцахгүй

өгөгдөл гарын хурууны хээг уншигч төхөөрөмж, серверүүдийг зогсоож, байгууллагад хадгалагдсан гарын хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгах үйл ажиллагааг акт үйлдэн баримтжуулж, тушаал гарган хүснэгтийн дагуу мэдээллийг цаг хугацаанд нь хургуулж ажилласан.

**5. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/789 дугаар захирамжийн хэрэгжилт**

**Заалт:** Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай.

**Хэрэгжилт:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д зааснаас бусад байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа, нийслэлийн өмчид бүртгэлтэй суудлын автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хургуулж, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авч ажиллана уу гэсэн захирамжийн дагуу Улаанбаатар театрт албан хэрэгцээнд ашиглагддаг суудлын автомашинтай албан хаагч байхгүй бөгөөд бусад заалтыг хэрэгжүүлж ажиллах болно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: "БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН"**

**3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт:**

**a/ Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1. МУ-ын Засаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тундрын удирдлагын тухай хууль, “Төрийн албаны тухай хууль, соёлын тухай”-ийн биелэлтийг хангаж ажиллах, хэрэгжилтийг хангаж ажиллана.

**Хэрэгжилт:** Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж үндсэн орон тоонд сонсголын бэрхшээлтэй 1, өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон 1 албан хаагчийг ажиллуулж байна. Эдгээр албан хаагчдын ажлын цагийг богиносгож, ачааллыг бууруулах хэлбэрээр ажил амралтын цагийг зохицуулж ажилладаг. Театрын байранд үйлчлүүлэхээр ирсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандарт хангасан авто зогсоол, зорчих зам, ариун цэврийн өрөөг тохижуулсан.

**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.**

**Хэрэгжилт:** Нийслэлийн Аудитын газар, Нийслэлийн дотоод аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмж, батлагдсан төсвийн хүрээнд дэх орлого зарлагын гүйлгээ, 2022 оны жилийн төсөв, сар улирлын тайлан мэдээ болон холбогдох баримтуудыг мэдээллийн самбар болон өөрийн байгууллагын цахим хуудас, шилэн дансанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.

**b/ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн үйл ажиллагаа**

1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах

**Хэрэгжилт:** Улаанбаатар театр нь телевизуудтэй хамтран “Цагаан сарын бичлэг” Mongol HD , ETV телевиз. “Цагаан сарын тогтолт” Mongol HD телевиз, MONGOL-TV, “Сар шинийн Улаанбаатар” онлайн тогтолтыг “Юнивишн”, “Ддиш” IPTV-үүдтэй хамтран шууд дамжуулалт хийхээс гадна сар шинийн баярын өдруудээр TV9 телевизээр дамжуулав.

2 . Соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх. /ковидоос шалтгаалж/.

**Хэрэгжилт:** Турк Улсын ЭСЯ-тай хамтран зохион байгуулсан "Турк ардын хөгжмийн мастерууд Монголд" тоглолтыг 4 дүгээр сарын 08, 09-ны өдрүүдэд театрын уран бүтээлчидтэй хамтран Саз хөгжмийн зэмсгээр ардын хөгжмийн дээжийг өвөрмөц арга барил, техникээр тоглож Монголын ард түмний сонорт хургэсэн. Мөн Солонгос Улсын соёлын хамтын ажиллагааны төвийн И Гуан Гу захиралд урилга хүргүүлж 2022 онд хамтын ажиллагааны хурээнд олон төрлийн соёлын үйл ажиллагаа болон тогтолтуудыг зохион байгуулах, туршлага солилцох арга хэмжээнүүдийг зохион байгуулж хоёр талын харилцааг сайжруулах зорилгоор гэрээ хэлэлцээр хийлээ. Мөн 10-12 сард Иксан хотын урлагийн төвүүдээс Монголд айлчилж театрын үйл ажиллагаатай танилцахаар боллоо. Мөн дотоодын орон нутгийн театруудтай хамтын ажиллагааг эхлүүлж, Завхан аймгийн Хөгжимт Жүжгийн Театр, Төв аймгийн Монгол туургатан, Сүхбаатар аймгийн Жаахан шарга, Дархан-Уул аймгийн Залуучууд театр, Хэнтий аймгийн Хан Хэнтий чуулга, Архангай аймгийн Хөгжимт Жүжгийн Театртай хамтын ажиллагааны гэрээг үзэглэсэн.

3. Шинэлэг хэлбэрийн урсгал чиглэлээр хамтарсан уран бүтээл туурвих сэтгэлгээг дэмжин, дуучид, хөгжимчид, бужигчдийн тайлан тоглолтыг зохион байгуулах, бүх талаар дэмжиж ажиллах. /ковидоос шалтгаалж/

**Хэрэгжилт:** 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар театрын тайзнаа Олон Улсын эмэгтэйчүүдийн баярт зориулсан "ХАЙРЛАЯ" хүндэтгэлийн тоглолтыг дуучин МУСТА Н.Бямбадорж, МУСТА Т.Бат-Очир нар хамтран тоглож бүсгүйчүүдээс бэлэг барьсан. 2022 оны 03 дугаар сарын 08-нд Улаанбаатар театрын тайзнаа Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Амин ээжүүд" -хүндэтгэлийн тоглолт болж өнгөрлөө.

Улаанбаатар театрын гоцпол хөгжимчийн "FIVE TONES" хөгжмийн тоглолт 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Улаанбаатар театрын тайзнаа тоглосон. Улаанбаатар 5 жилийн өмнө эхлүүлсэн таван хөгжмийн зэмсэг, таван хөгжимчний аялал үргэлжилсээр байна. Үндэсний хөгжмийн зэмсгээр дэлхий нийтэд танигдсан алдарт хөгжмийн зохиолчдын бүтээлүүдээс дээжлэн тоглож, эрхэм үзэгчдийнх сонорыг мялаасан тоглолт болсон.

МУСТА Х.Бархүү, МУСТА Б.Мягмарцэрэн, "Авьяаслаг Монголчууд I" шоуны финалын оролцогчид болох гоцпол хөгжимчид, Энэ орчлонд эхийн минь сэтгэл шиг ариун, зээжийн минь хайр шиг үнэн, үрсийн минь инээд шиг гэгээн зүйл үгүй. Хорвоо дэлхийг хайрын илчээрээ дулаацуулж байдаг бүх сайхан ээжүүддээ "Халуун зүрх" тоглолтоо үзэгч түмэнд шинэ уран бүтээлзэсээ толилуулсан. Дээрх тоглолтуудад нийт 1500 гаруй үзэгчдийг хамруулсан.

**4. Театрын урын санг баяжуулах зорилгоор онлайн болон тайзны тоглолтыг найруулан тавина.**

**Хэрэгжилт:** "Ах дүү Гrimmийн Бремен хотын хэрмэл хөгжимчид үлгэрээс сэдэвлэсэн "Анхны үнсэлт" мюзиклээ Улаанбаатар театрын уран бүтээлчид тайзнаа дахин амилуулах гэж байна. Германы Бремен хотын хөгжимчид болохоор ирсэн авьяаслаг хөгжимчин, дур булаам залуу Трубадур түүний нөхөд илжиг, нохой, муур, тахиа нартай Бремен хотын хааны үзэсгэлэнт гүнжтэй таарч хайртай болсноор тэдний толгой эргэм адал явдал, хөгжилтэй, ая дуугаар дүүрэн гайхамшигт аялал үргэлжлэх юм.

Улаанбаатар театр XX зууны алдарт хөгжмийн зохиолч И.Ф.Стравинскийн суут түүрвил "Ариун хаврын тахилга" бүтээлийг Дэлхийн бүжгийн өдөрт зориулан 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр тайзнаа дахин амилуулан тоглосон.

Уг бүтээлийг Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран Соёл урлагийг дэмжигч "Төгөлдөр сан"-гийн ивээн тэтгэлгээр монголын үндэсний хөгжимд хөрвүүлэн найруулж, үндэсний бүжгийн уламжлалыг модерн бүжигтэй хослуулан шинээр дэглэсэн нь Монголын ардын хөгжмийн зэмсгийн уран сайхны илэрхийллийг нээж таниулсан, Монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг харуулж буй уран бүтээлийн томоохон эрэл хайгуул болсон бүтээл болсон.

**6. Урлаг, театр судалгааны чиглэлээр судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний болон онол-практикийн хурал, семинар зохион байгуулна.**

**Хэрэгжилт:** "Монголын театрын үүсэл, өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Улаанбаатар театр санаачлан зохион байгуулсан.

Тус хурлаар өнөөгийн Монголын хөгжмийн театрын түүх, цаашдын хөгжлийн чиг хандлага, тулгамдаж буй асуудлуудын талаар Монголын урлаг судлаач, эрдэмтэн докторууд өөр өөрийн судалгаа шинжилгээнд тулгуурлан илтгэл тавьсан. Улаанбаатар чуулга байгуулагдаад 15 жилийн ойн дээрээ Улаанбаатар театр болж нэршлээ өөрчилсөн тул цаашдын театрын уран бүтээл, үйл ажиллагааны чиглэл, урын сангийн бодлого тодорхойлох чиг үүрэг авах зорилгоор тус эрдэмтдийг урьж хурлыг зохион байгуулсан.

Үйл ажиллагаа нь 2021 оны 01 сарын 14-ний өдөр Монгол Улсын Консерваторийн А зааланд амжилттай зохион байгуулагдаж өнгөрлөө. Зохион байгуулагч, Модератор Б.Сүхээ /МУК-ын багш, доктор/

**Илтгэгчид:**

- Б.Батжаргал /МУК-ын багш, Доктор/
- Г.Эрдэнэбаатар /УДБЭТ-ын ерөнхий найруулагч, МУСТА, Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналт/
- С.Энхбулаг /МУК-ын багш, Доктор/,
- Т.Сэр-Од /СУИС-ын багш, МУГЗ, Хөгжмийн зохиолч/
- Д.Ариунаа /СУИС-ын багш, Доктор/
- Э.Зулцэцэг /СУИС-ын багш, Доктор/
- С.Соронзонболд /Хөгжмийн зохиолч, Доктор/ нар өөр өөрсдийн сэдвээр илтгэл тавьсан.
- 

**7. Тухайн жилийн санхүүгийн тайланг, Төрийн сангийн хэлтэст хянуулж ажиллана.**

**Хэрэгжилт:** НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд мэдээ, санхүүгийн тайланг хургуулэн баталгаажуулан байгууллагын цахим хуудсанд Төсөв, санхүүгийн ил тод байдал, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2022 оны жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгнөөс дээш гүйлгээний орлого, зарлагын мэдээлэл болон бусад холбогдох баримт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон шилэн дансанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.

## в/ Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг

### 1. Албан хаагчдыг мэргэжлийн сургалтад хамруулна. /Цахим болон танхим/

**Хэрэгжилт:** Эхний хагас жилд тайз техникийн ажилчдад болон нийт албан хаагчдад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал-эрүүл ахуйн сургалтыг 5 дугаар сарын 03-ны өдөр Ажил олгогч ээдийн холбоотой хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтад нийт 39 албан хаагч хамрагдсан. Түүнчлэн, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн сургалтан хамрагдаж байгаа 7 албан хаагчийн ажлын цагийг уян хатан нөхцөөр зохицуулалт хийж ажилласан.

### 2. Одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг албан хаагчдад таниулан хэрэгжилтийг хангаж ажиллах.

**Хэрэгжилт:** Улаанбаатар театр болж өргөжсан мөн 2022 оны 1 сарын 01-нээс эхлэн шинэчлэгдэж мөрдөж эхэлсэн хуулиудтай холбоотойгоор байгууллагын хэмжээнд мөрдөгддөг дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж театрын даргаар батлуулсан. Үүнд, Хөдөлмөрийн дотоод журам, Театрын ёс зүйн дүрэм, архив, албан хэрэг хөтлөлтийн журмууд, Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл тооцох журам, Хурлын журам, Албан тушаалын тодорхойлолт гэх зэрэг 30 гаруй нэр төрлийн дүрэм, журам, зааврыг шинэчлэн баталж, албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Мэдээллийн самбар болон театрын албан хаагчдын UB ensemble STAFF фейсбууук групп-ээр танилцуулж ажилласан.

### 3. Театрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, мансууруулах бодис хорт зуршилаас урьдчилан сэргийлэх, ажлын байран дахь сэтгэл зүйн зерэг хандлагын талаар сургалтыг зохион байгуулахад байгуулах.

**Хэрэгжилт:** Театрын албан хаагчдад зориулсан 2022 оны сургалтын төлөвлөгөөнд Төрийн албан хаагчийн ёс зүй, мансууруулах бодис хорт зуршилаас урьдчилан сэргийлэх, ажлын байран дахь сэтгэл зүйн зерэг хандлагын талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Тайлант хугацаанд төлөвлөсний дагуу 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Сэтгэл судлаач Я. Болорчимэгийн Ажлын байран дахь стресс түүнээс гарах арга зам сэдэвт сургалтыг театрын нийт албан хаагчдад зориулан зохион байгуулсан. Тус сургалтанд нийт 44 албан хаагч оролцож, тухайн сэдвийн талаар шинэ шинэ мэдээлэл авч, санал бодлоо солилцсон үр дүнтэй сургалт боллоо. Дараагийн сургалтыг 4 дүгээр улиралд багтаан явуулахаар төлөвлөсөн.

### 4. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай хуулийг мөрдөж ажиллах

**Хэрэгжилт:** "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, театрын албан хаагчдад зориулсан төлөвлөгөөг гаргаж, 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдөр театрын даргаар батлуулан мөрдөж ажилласан. Энэхүү төлөвлөгөө нь тус тогтоолоор олгосон 8 үүргийн 19 хэрэгжүүлэх арга хэмжээний бүтэцтэйгээр төлөвлөгдсөн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажлын байрны сахилга бат-дэг журам, архидан согтууралт, ялгаварлан гадуурхалт, бэлгийн болон ажлын байрны дарамтыг үл тэвчих ажлуудыг зохион байгуулж, албан хаагчдад анхаарал санамжийг тухай бүр өгч, мэдээллийг самбарт байршуулан хяналт тавьж ажилласан. Тайлангийн хугацаанд сахилга батын зөрчил гаргаж, ажлын байранд архидан согтуурсан гоцлол хөгжимчин А..Мөнгөний албан тушаалыг бууруулж хөгжимчин албан тушаалд, морин хуур хөгжимчин Б.Бат-Өрнөхийн сарын үндсэн цалинг 3 сарын хугацаатай 20%-иар бууруулах, лимбэ хөгжимчин Б.Мягмарцэрэнд

тушаалаар сануулах арга хэмжээг тус тус авсан. Мөн захиалгат тоглолтыг хүндэтгэх шалтгаангүй тасалсан дуучин С.Эрдэнэцэцэг, дуучин О.Анхчимэг, дуучин Д.Шижирмаа нарт анхны удаагийн аман сануулгыг захиргааны зөвлөлөөс өгсөн. Дээрх 2 зөрчлөөс гадна Төрийн албаны сахилга, дэг журмыг зөрчиж алдаа дутагдал гаргасан тохиолдол байхгүй байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад зөрчлийн хувь буурсан үзүүлэлттэй байна.

**5. Аж ахуйн нээж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан байна.**

**Хэрэгжилт:** Тайз техникийн ажилчдад өдөр бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааны журам, цахилгаан хэрэгсэлтэй ажиллах зааварчилгаа, өргөх буулгах механизмтай ажиллах зааварчилгаа, галын аюулгүй байдлын зааварчилгаа, утааны шингэнтэй харьцах мэдээлэл зэргийг тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Б.Түмэндэлгэр хариуцан тогтмол зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж, ажилд гаргаж хэвшсэн. 2022 оны хагас жилийн байдлаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн тохиолдол гараагүй. Мөн байгууллагын орчинд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт бүрэн хангагдсан. Байгууллагын ажилтан, албан хаагч, нийт уран бүтээлчдэд зориулсан эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, уран бүтээлчдийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

**6. Архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан, мэдээ гаргах, архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэх.**

**Хэрэгжилт:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим баримт бичгийн солилцоо” стандарт /MNS ISO 17933:2008/, 2021 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн C/30 дугаар тушаалаар батлагдсан. “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140-1:2021, MNS 5140 2:2021, MNS 5140-3:2021/ мөрдөн ажиллаж байна. Театрын албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг [edoc.ulaanbaatar.mn](http://edoc.ulaanbaatar.mn) домайн нэр бүхий онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр хөтлөн явуулж, цахим хэлбэрээр үүссэн баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулж, мэдээ гаргах, архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэх ажлыг архивын эрхлэгч, Дотоод ажил тайлан мэдээ, оичиг хэрэг хариуцан мэргэжилтэн нар хариуцан ажиллаж байна.

**7. Хариутай албан бичгийээ хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллах.**

**Хэрэгжилт:** Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, судалж шийдвэрлэх, хариу өгөх болон мэдээлэл-лавлагаанд шаардлагатай бүх баримт бичгийг хүлээн авч, бүртгэн үйл ажиллагааг [edoc.ulaanbaatar.mn](http://edoc.ulaanbaatar.mn) онлайн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандaa буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

## 8. Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллах

**Хэрэгжилт:** Театрын захиргаанд хандаж нийт 16 өргөдөл ирсэн. Иргэнээс 5, албан хаагчдаас 11 өргөдөл хүсэлт гаргаснаас ажилд орохоор 5, ажлаас чөлөөлөгдөх 6, жирэмсний амралт авах 1, эзлжийн амралтын цалин урьдчилж авахаар 2, хүүхэд асрах чөлөө авахаар 2 хүсэлт ирсэн байна.

Эдгээр хүсэлтуудийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн хүсэлт гаргасан иргэн хариу өгч ажилласан. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь өргөдөл гаргагчийн зүгээс ирүүлсэн гомдол санал байхгүй байна. ERP систем дэх өргөдөл гомдлын тайлангаар: Өргөдөл гомдлын индекс 0.789, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чанарын индекс 0.999, шийдвэрлэлтийн инкекс 0.938 байна

## 9. Дээд газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлыг дотоод хяналтад авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

### 10. Байгууллагын хагас, бүтэн жилийн тайлан мэдээнд хяналт шалгалт хийх

**Хэрэгжилт:** Тус театрын бүтэц, орон тооноос хамаарч, Дотоод хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэний албан тушаалыг Маркетингийн менежер М.Энхтуул хавсрان гүйцэтгэх байх хугацаандаа байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, театрн даргаар батлуулсан.

Хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн М.Энхтуул өөрийн хүсэлтээр 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн тул 2022 оны эхний хагас жилийн тайлан мэдээнд хяналт шинжилгээ хийгдээгүй байна.

## Г/ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайруулах үйл ажиллагаа

### 1. Улаанбаатар чуулгын үзэгчдийн сэтгэл ханамжийн байдалд судалгаа хийж, дүгнэлтийг үйл ажиллагаандaa хэрэгжүүлнэ.

**Хэрэгжилт:** Үйл ажиллагаа онлайн горимд шижлсэнээр Улаанбаатар чуулга сэтгэл ханамжийн судалгааг тандалт хийж авсан. Тандалт судалгааны аргаар сэтгэл ханамжийг дүгнэхэд биечлэн асуулга авсанаас харьцангуй цөөн байсан боловч интернет орчин болон IPTV-ээр дамжуулан үзэгчдэд урлагийн үйлчилгээ үзүүлэх нь өнөөгийн нөхцөл байдалд хамгийн тохиромжтойгоос гадна хэрэглэгчид сэтгэл ханамж өндөр байгаа боловч уран бүтээлчид сошиал орчинд хангалттай идэвхитэй биш, хэрхэн хөгжүүлэлт хийхээ мэдэхгүй байгаа нь үйл ажиллагаа, уран бүтээлүүдээ бүрэн харуулж чадахгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Иймд 6 дугаар сарын 9-ний өдөр "Сошиал маркетинг, Цахим орчинд бизнесээ хэрхэн удирдах вэ"буюу брэндбүүк үүсгэх, сошиал орчинд хэрхэн идэвхтэй% үр дүнтэй ажиллах тухай сургалтыг ментор, дижитал маркетер Н.Лайханыг Улаанбаатар чуулгад урин эхний сургалтыг зохион байгуулаад байна. Цаашид цуврал сургалтанд уран бүтээлчид, захиргааны албан хаагчдыг хамруулж, үр дүнтэй ажиллах төлөвлөгөөтэй байна.

### 2. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтанд хяналтыг бүрдүүлж, хяналт тавин ажиллана.

**Хэрэгжилт:** Мөн урсгал зардлыг батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу зарцуулан үйл ажиллагаагаа явуулж, өр төлбөр үүсгэлгүй хэмнэж зарим зардлуудад хязгаар тогтоосон бөгөөд албан тасалгаануудын дотоод дулааныг хэвийн хэмжээнд барьж, их танхимын дулааныг зөвхөн хүлээн авалт үйл ажиллагаатай үеэр дулаан нэмэлтээр өгч

хэвийн үйл ажиллагааг хангах замаар чуулгын байрны өмч ашиглалтыг сайжруулан ажиллаж байна.

### **Манлайллын зорилтын хүрээнд**

1. Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг биечлэн хангах.

**Хэрэгжилт:** 1.Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх

-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор “Улаанбаатар театр” орон нутгийн өмчит үйлдвэрлэлийн газар болгож өөрчилсөнтэй холбогдуулан байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавар, хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдаж албан хаагч тус бүр дүрэм журам, заавар хөтөлбөрийг шинэчлэж дуусгасан.

2.Ажилтнуудын нийгмийн асуудлыг холбогдох хууль, тогтоомж байгууллагын дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллах.

-Албан хаагч, уран бүтээлчдээс ур чадварын аттестатчлалын шалгалт авч, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, удирдан манлайлах чадавхыг хөгжүүлэхэд анхаарч ур чадварын шалгалтыг 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нийт 41 уран бүтээлчийг хамруулсан. Хөндлөнгийн буюу гадны шүүгчээр 9 хүн ирж ажилласан.

Хууль,	эрх	зүйн	мэдлэгээ	дээшлүүлэх
--------	-----	------	----------	------------

**Хэрэгжилт:** Санхүүгийн мэдлэг, бүх төрлийн даатгалын мэдлэг, төрийн албаны тухай хуулийн мэдлэгийг сайжруулах зорилгоор санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж сургалтыг цахимаар авч эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж ажилласан.

3. Мэргэжлийн өндөр ур чадвар бүхий баг бүрдүүлж ажиллах.

**Хэрэгжилт:** Мэргэжлийн урлагийн байгууллага гэдэг онцлогоос шалтгаалж, шинэ санал санаачлага дэвшүүлсэн уран бүтээлчдийг дэмжих театрын хөгжмийн бүрэлдэхүүнд зориулж ардын болон цахилгаан хөгжмөөр гадаадын том том бүтээлийг найруулж урын сангаа баяжуулах зорилгоор хөгжмийн зохиолч О.Чинбаттай хөдөлмөрийн гэрээ байгуулан хамтарч ажиллаж байна. Мөн Улаанбаатар театрыг өөрийн удирдаачтай болгохын тулд их хуур хөгжимчин Б.Эрхэмбаярыг Монголын Улсын Консерваторид удирдаачаар сургаж төгсгесэн. Мөн уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хөрвөх ур чадвар эзэмшүүлэх, хос мэргэжил эзэмшүүлэх зэрэг асуудлууд дээр анхаарч ажилласан.

### **Уран бүтээлч нарын оролцсон тоглолтын хэсгээс**

2022 оны 03 дугаар сарын 07-ний өдөр Улаанбаатар театрын тайзнаа Олон Улсын эмэгтэйчүүдийн баярт зориулсан “ХАЙРЛАЯ” -хүндэтгэлийн тоглолтыг дуучин МУСТАН.Бямбадорж, МУСТА Т.Бат-Очир нар хамтран тоглож бүсгүйчүүдээ бэлэг барьсан.



2022 оны 03 дугаар сарын 08-ний өдөр Улаанбаатар театрын тайзнаа Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Амин ээжүүд” -хүндэтгэлийн тоглолт болж өнгөрлөө.



2022 оны 03 дугаар сарын 27-ний өдөр TV9 телевизийн “сар шинийн өглөө” концертын бичлэгт Улаанбаатар чуулгын бүжигчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон бөгөөд тус тоглолт цагаан сарын шинийн нэгний өдөр үзэгч олонд хүрсэн билээ.



Улаанбаатар театр, Хан Хэнтий чуулга болон Хүн театрын хамтарсан ҮЛЭМЖ ТӨГӨЛДӨР бүжгийн 2022.03.04-05-нд Хүн театрын тайзнаа тоглосон.




Улаанбаатар театр Турк Улсын ЭСЯ-тай хамтран “Турк ардын хөгжмийн мастерууд Монголд” тоглолтыг 2022 оны 4 дүгээр сарын 08, 09-ны өдрүүдэд Анатолийн бус нутгийн Саз хөгжмийн зэмсгээр төрөл бүрийн ардын хөгжмийн дээжийг өвөрмөц арга барил, техникээр тоглож, Монголын ард түмэн, ахан дүүстээ тоглож сонирхуулсан.



Ах дүү Гrimmийн Бремен хотын хэрмэл хөгжимчид үлгэрээс сэдэвлэсэн "Анхны үнсэлт" мюзиклээ Улаанбаатар театрны уран бүтээлчид тайзнаа дахин амилуулах гэж байна. Германы Бремен хотын хөгжимчид болохоор ирсэн авьяаслаг хөгжимчин, дур булаам залуу Трубадур түүний нөхөд илжиг, нохой, муур, тахиа нартай Бремен хотын хааны үзэсгэлэнт гүнжтэй таарч хайртай болсноор тэдний толгой эргэм адал явдал, хөгжилтэй, ая дуугаар дүүрэн гайхамшигт аялал үргэлжлэх юм




Улаанбаатар театр ХХ зууны алдарт хөгжмийн зохиолч И.Ф.Стравинскийн суут туурвил “Ариун хаврын тахилга” бүтээлийг Дэлхийн бүжгийн өдөрт зориулан 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр тайзнаа дахин амилуулан тогlossen. Уг бүтээлийг Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран Соёл урлагийг дэмжигч “Төгөлдөр сан”-гийн ивээн тэтгэлгээр монголын үндэсний хөгжимд хөрвүүлэн найруулж, үндэсний бүжгийн уламжлалыг модерн бүжигтэй хослуулан шинээр дэглэсэн нь Монголын ардын хөгжмийн зэмсгийн уран сайхны илэрхийллийг нээж таниулсан, Монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг харуулж буй уран бүтээлийн томоохон эрэл хайгуул болсон бүтээл болсон.



Улаанбаатар театрын гоцпол хөгжимчдийн “FIVE TONES” хөгжмийн тоглолт 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Улаанбаатар театрын тайзнаа тогlossen. Улаанбаатар 5 жилийн өмнө эхлүүлсэн таван хөг, таван хөгжмийн зэмсэг, таван хөгжимчний аялал үргэлжилсээр байна. Үндэсний хөгжмийн зэмсгээр дэлхий нийтэд танигдсан алдарт хөгжмийн зохиолчдын бүтээлүүдээс дээжлэн тоглож, эрхэм үзэгчдийнх сонорыг мялаасан тоглолт болсон.



МУСТА Х.Бархүү, МУСТА Б.Мягмарцэрэн, "Авьяаслаг Монголчууд I" шоуны финалын оролцогчид болох гоцтол хөгжимчид, Энэ орчлонд эхийн минь сэтгэл шиг ариун, ээжийн минь хайр шиг үнэн, үрсийн минь инээд шиг гэгээн зүйл үгүй. Хорвоо дэлхийг хайрын илчээрээ дулаацуулж байдаг бүх сайхан зэжууддээ "Халуун зүрх" тоглолтоо үзэгч түмэнд шинэ уран бүтээлзэсээ толилуулсан.



2022 ОНЫ ХАГАС ЖИЛД Улаанбаатар театрын Нийт уран бүтээлчид тоглолтонд оролцсон тоон мэдээлэл

ЕТГ	7	Өөрийн байранд тоглосон тоглолт:	21
УИХ	3	Оролцсон уран бүтээлчид:	656
Шадар сайд	1	Үзэгчдийн тоо:	6974
ХНХЯ	2	Гадуур захиалгат ажил:	65
СЯ	1	Оролцсон уран бүтээлчид:	781
НИТХ	15	Үзэгчдийн тоо:	28280
НЭДТГ, харьяа газрууд	30		
УБЧ	23		
БНТуркУ ЭСЯ	4		

Нийт ажлын тоо:	86
Нийт оролцсон уран бүтээлчдийн тоо /давхардсан тоогоор/:	1437
Нийт үзэгчдийн тоо /давхардсан тоогоор/:	35254

## 2/ Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг баримтлан ажилласан.

8.1.1. Сул орон тооны зарыг цахим сүлжээ болон мэдээллийн самбartaа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах гэсэн заалтын дагуу:

- 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Улаанбаатар театрын батлагдсан орон тоо 61. Одоо ажиллаж байгаа 60. Тайлант хугацаанд гэрэлтуулэгч, маркетингийн менежерийн орон тоон дээр ажиллаж байсан Б.Доржпүрэв, М.Энхтуул нар өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөний дагуу сул орон тооны зарыг театрын сошиал хуудас болон [www.ubtheatre.mn](http://www.ubtheatre.mn) сайтаар нээлттэй зарлаж гэрэлтуулэгчийн үүрэгт ажилд Л.Баянмөнхийг, маркетингийн менежерийн үүрэгт ажилд Д.Мижидбатыг сонгож авсан. Маркетингийн менежер Д.Мижидбат 2 сарын хугацаанд маркетингийн менежерээр ажиллаж байгаад туршилтын хугацаа дуусгалгүй өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн. Одоогоор маркетингийн менежерийн албан тушаалын сул орон тоог дахин нээлттэй зарлаад байна.

8.1.2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбartaа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх гэсэн заалтын дагуу:

- Улаанбаатар театр болж өргөжсөний дагуу Улаанбаатар чуулгын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан Улаанбаатар чуулгын ёс зүйн дүрмийг хүчингүй болгож, Театрын даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан "Улаанбаатар театр" ёс зүйн дүрэм"-ийг баримтлан ажиллаж байна. Шинээр баталсан ёс зүйн дүрмийг [www.ubtheatre.mn](http://www.ubtheatre.mn) цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан, дүрэм журмын хавтас нээж албан хаагч нарт танилцуулсан. 2022 оны эхний хагас жилд ёс зүйн зөрчил гаргаж арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй болно.

8.1.3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх заалтын дагуу:

-Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратегийн гол асуудал болох чадварлаг хүний нөөцийг сонгон авч түүнийг тогтвортой суурьшилтай ажиллуулах, ажлын бүтээмж, ур чадварыг бодитой үнэлэх, урамшуулах, сэтгэл ханамжийг өндөр байлгах тал дээр анхаарч ажилладаг. Нийслэлийн харьяа мэргэжлийн урлагийн байгууллагын хувьд Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ Монгол Улсын Төрийн албан тухай хууль, Соёлын тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан гаргасан Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" А/657 дугаар захирамжаар Улаанбаатар театрын дэд даргын орон тоог хасаж 61 хүний орон тоотой ажиллуулахаар баталж өгсний дагуу Улаанбаатар театрин даргын 2022 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Б/28 дугаар тушаалаар театрин дэд дарга Баасанжавын Баатархүүг үүрэгт ажлаас чөлөөлсөн. Театрын албан тушаалын тодорхойлолтыг театрин даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталж, албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Албан тушаалын тодорхойлолтод нийцсэн чадварлаг мэргэжлийн хүмүүсээр нөөцөө бүрдүүлэн, албан хаагчдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс, нэмэгдэл олговор, шагнал урамшуулал, тусламж дэмжлэгийг зохих журмын дагуу олгож, шинэчлэн баталсан албан хаагчийн сургалтын хөтөлбөр, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улирал бүр хийж, захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, ур чадварын нэмэгдэл, ур дүнгийн урамшууллын хөлсийг олгож хэвшсэн.

#### **8.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр аж хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх заалтын дагуу:**

-Байгууллагын нэр өөрчлөгдөж Улаанбаатар театр болж өргөжсентэй холбогдуулан байгууллагын албан ёсны вебсайтын домэйн нэрийг өөрчилж, [www.ubtheatre.mn](http://www.ubtheatre.mn) веб сайтыг ажиллагаанд оруулж, хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажилласан. Тушаал шийдвэрийг веб хуудсанд байршуулахдаа Хувь хүний нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг нээлттэй мэдээлэхгүй байх чиглэлийн дагуу ажилласан. Вебийн шинэ бүтцэд албан хаагчдын танилцуулга, албан тушаалын тодорхойлолтууд, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр түүний биелэлтүүд, сургалтын хөтөлбөр түүний хэрэгжилтийн тайлан, албан хаагчдын ур чадвар, ажлын ачаалалыг үнэлж дүгнэсэн байдал, сүл орон тооны тухай мэдээлэл, шинээр ажилд орсон албан хаагчдын талаарх мэдээлэл гэх мэтчилэн байгууллагын хүний нөөцийн удирдлагын талаарх бүхий л мэдээллийг тайлагнаж, ил тод мэдээлэх нөхцөл бүрдүүлэн ажилласан. Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг мэдээллийн самбар болон сошиал сүлжээн дэх өөрийн цахим хуудсанд байршуулан мэдээлж, тухай бүр шинэчилж ажилласан. Мөн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг [www.ubtheatre.mn](http://www.ubtheatre.mn) сайт болон дотоод үйл ажиллагаанд албан хаагчдад нээлттэй танилцуулах хавтсанд хийж хадгалж, түүний баяжилтыг тухай бүр хийж хэвшсэн.

8.1.6. Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх заалтын дагуу: Хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаархи үнэн зөв мэдээллийг бэлтгэн, байгууллагын мэдээллийн самбар болон дотоод ажлын UB THEATRE STAFF группээр дамжуулан албан хаагчдад цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.

**Нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:** Бакалавр, магистрын чиглэлээр мэргэжлийн сургуульд элсэн суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцлийг хангаж, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажилласан.

**Дотоодын их дээд сургуулиудад суралцаж байгаа албан хаагчид:**

№	Нэр	Сургууль	Мэргэжил	Зэрэг, дэв
1	Э.Дашням	Соёл урлагийн Их сургууль	Дуулах урлаг	магистр
2	Б.Эрхэмбаяр	Монгол Улсын Консерватори	Хөгжмийн удирдаач	магистр
3	Ц.Энхмаа	Соёл урлагийн Их сургууль	Хөгжимчин-багш	бакалавр
4	Т.Санжаажамц	Соёл урлагийн Их сургууль	Хөгжмийн багш, хөгжимчин	бакалавр
6	А.Уганбаяр	Соёл урлагийн Их сургууль	Хөгжимчин	Магистр
7	О.Ганзаяа	Соёл урлагийн Их сургууль	Бүжгийн найруулга	Бакалавр

Мөн морин хуур хөгжимчин Г.Энхбат Монголын Урлагийн Зөвлөлийн "Соёл урлагийн залуу Манлайлагч" хөтөлбөрт хамрагдан 2022 оны 6 дугаар сарын 13-нд төгссөн. Төгсөлтийн тайлангийн ажлаа "Бидний үзээгүй Улаанбаатар буюу Unseen UB" гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж ажилласан.

• **Нэг удаагийн тусламж дэмжлэг:**

- Ар гэрт нь гачигдал гарсан болон эрүүл мэндийн байдал ковидын хүндрэлээс болж урь хугацааны эмчилгээ хийлгэж байгаа 1, нийт 4 албан хаагчидчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгов.

№	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Шалтгаан	Мөнгө дүн
1	Т.Цолмон	Дууны техникч	Төрсөн эцэг нас барсан	300.000
2	Б.Гэрэлтуяа	Шанз хөгжимчин	Эмээ нас барсан	200.000
3	Б.Сувд-Эрдэнэ	Архивын эрхлэгч	Эмчилгээний зардалд	300.000
4	С.Ганзориг	Гоцлол дуучин	Төрсөн эцэг нас барсан	300.000

Хүүхдийн баяраар чуулгын албан хаагчдын 97 хүүхдэд Номин их дэлгүүрийн хүүхдийн бэлгээр албан хаагчдынхаа хүүхдүүдэд бэлэг барьж, театрын эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан Хүүхдийн баярт зориулсан өдөрлөгийн үеэр гардуулсан. Тус үйл ажиллагаанд зориулагдсан **3.027.463** төгрөгийн зардлыг театрын даргын тушаалаар, зохих журмын дагуу байгууллагын төсвөөс гаргаж санхүүжүүлсэн.

### 3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Улаанбаатар театр нь иргэд болон албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэлийг UB ERP систем дэх "Өргөдөл, гомдлын нэгдсэн программ" цахим программ ашиглан өргөдөл, гомдлыг бүртгэж хянан шийдвэрлэдэг. Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан иргэдээс ажилд орох хүсэлт, албан хаагчдаас ажлаас түр болон бүр чөлөөлөгдхөн хүсэлтүүд, бусад ажлын гүйцэтгэл, сахилга бат, нийгмийн байдлыг шийдвэрлүүлэх хүсэлтүүд ирснээр театрын дарга тухайн өргөдөлтэй танилцан шаардлагатай тохиолдолд чуулгын захиргааны зөвлөл болон уран сайхны зөвлөл хуралдан шийдвэрлэдэг. 2022 онд 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар

театрын захиргаанд хандаж албан хаагчаас 13, иргэдээс 5 өргөдөл ирүүлснийг бүртгэж, 95.8 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 1 өргөдөл шийдвэрлэх хугацаа болоогүй, судлах шатанд явж байна.

## 2 Албан хаагчдад хийгдсэн сургалтууд:

- Ublegal.ulaanbaatar.mn цахим хуудас ашиглалтын сургалт
- Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалт
- Жендерийн эрх, тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн талаарх ойлголт сургалт
- Ажлын байран дах стресс, түүнээс гарах арга зам сургалт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт
- Олон үндэстний хөгжмийн танилцуулга мастеркласс
- "Жендер ба хүний эрх" сургалт,
- Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй" онлайн сургалт,
- Төрийн албаны Зөвлөлийн 7:4:10 арга зүйн сургалт
- Улсын үзлэг, тооллогын арга зүйн сургалт
- Модерн дээс бүжгийн мэргэшүүлэх сургалт
- Ажлын байран дах зөв хооллолт
  
- **Шагнал, бусад амжилтууд**

№	Нэр	Албан тушаал	Шагналын төрөл
<b>Төрийн одон медаль:</b>			
1	Б.Мягмарцэрэн	Гоцпол хөгжимчин	"Алтан гадас" одон
2	Х.Бархуу	Гоцпол хөгжимчин	"Алтан гадас" одон
3	Ж.Буяントогох	Дуучин	"Алтан гадас" одон



Мөн, Лимбэ хөгжимчин, МУСТА Б.Мягмарцэрэн Оны шилдэг бүтээл, уран бүтээлч шалгаруулах "МӨНГӨН МОД" наадмаас шилдэг хөгжимчин номинацийн "МӨНГӨН МОД" шагналыг хүртсэн.

Монгол Улсын Ардын багш, МУГЖ Г.Долгорсүрэнгийн нэрэмжит "Гоцпол бүжигчдийн улсын анхдугаар уралдаан"-д тус театрын 5 бүжигчин мэргэжлийн ур чадвараа сорьж оролцсоноос, Гоцпол бүжигчин Бямбасүрэнгийн Норовбанзад "ТЭРГҮҮН БАЙР" эзэлсэн.

### 3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Улаанбаатар театр нь egr.ulaanbaatar.mn цахим программын Өргөдөл, гомдлын системийг ашиглан өргөдөл, гомдлыг бүртгэж хянан шийдвэрлэдэг.

Театрын захиргаанд хандаж нийт 16 өргөдөл ирсэн. Иргэнээс 5, албан хаагчдаас 13 өргөдөл хүсэлт гаргаснаас ажилд орохоор 5, ажлаас чөлөөлөгдхө 8, жирэмсний амралт авах 1, эзлжийн амралтын цалин урьдчилж авахаар 2, хүүхэд асрах чөлөө авахаар 2 хүсэлт ирсэн байна. Эдгээр хүсэлтүүдийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн, хүсэлт гаргасан иргэнд хариу өгч ажилласан. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь өргөдөл гаргагчийн зүгээс ирүүлсэн гомдол санал байхгүй байна. ERP систем дэх өргөдөл гомдлын тайлангаар: Өргөдөл гомдлын индекс 0.789, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чанарын индекс 0.999, шийдвэрлэлтийн инкекс 0.938 байна.

### 3.6 Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагч нарын байгуулсан үр дүнгийн гэрээнд заагдсан ажлуудыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэж 70 хувийн биелэлттэй байгаа бөгөөд мэдээ тайланг НЭДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

#### 1. Архивын ажлын зохион байгуулалт үйл ажиллагаа:

“Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” Баримт бичгийн стандарт MNS 5140-1:2021 “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” /ТАХХҮЗ/ “Тамга тэмдэг баталгааны тэмдэг хэрэглэх заавар” холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж Захиргааны албан бичиг боловсруулсан албан хаагчидас ирсэн явуулсан харилцсан бичиг тэдгээрийн хавсралт бүхий баримт бичгүүдийн боловсруулалт стандартын хэрэгжилтийн байдал хяналт тавьж ажиллаа.

Архивын сан хөмрөтт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам буюу 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн A/177 дугаар тоот журам, Монгол улсын засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх журам” Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн A/528 тоот “Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын дүрэм” Нийслэлийн засаг даргын 2015 оны 07 сарын 29-ны өдрийн A/633 дугаар захирамж” зэргийг дагаж мөрдөн ажиллаж байна.

Монгол улсын хууль дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн A/222 тоот журам буюу “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллаж байна.

Архив, албан хөтлөлтийн хэрэгцээнд Нийслэлийн Архивын газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн систем, тусгай төрлийн баримттай ажиллах арга зүй 2018” ном “Архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи эрх зүйн болон арга зүйн баримт бичгийн эмхэтгэл-2018” зэрэг номнуудыг авсан байна. Байгууллагын архивын дүрэм, журам, архивын аюулгүй ажиллагааны журам зэргийн шинээр боловсруулан батлуулсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор “Улаанбаатар театр” орон нутгийн өмчийт үйлдвэрлэлийн газар болгож өөрчилсентөй холбогдуулан ажлын хэсэг байгуулагдаж байгууллагын архивын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавар”-ыг шинэчлэх дүрэм журам, заавар шинэчлэж мөн Архивын гэрчилгээ солиулах хүсэлтээ холбогдох журмын дагуу Нийслэлийн архивын газарт явуулсан.